



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/89

Шивээговь сум

**Төсөл сонгон шалгаруулах ажлын  
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах, төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ын 9.1, 9.2, 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/79 дугаар захирамжийн дагуу малчдын хоршоонд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын төслийг үнэлж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Т.Өлзийбуд  
(Газрын даамал)

Гишүүд:

Д.Баттуул  
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

М.Гантуяа  
(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)


Д.Амартүвшин  
(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Түвшинжаргал  
(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2.Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ын дагуу зохион байгуулахыг (Ажлын хэсэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА